

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэ тгэлийн мониторинг” төслийн эхний үе шатны тайлан

Нэг. Төслийн зорилго, төслийн хүрээнд хийх ажлын талаар

1.1. Төслийн зорилго

“Газрын шинэ тгэлийн мониторинг” төсөл нь Газрын шинэ тгэлийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомжуудыг төв, орон нутагт хэрэгжүүлэхэд гарч буй эрсдлүүд түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавруудыг судлах, хуулийн хэрэгжилтэд олон нийтийн оролцоо, хяналтын механизмыг сайжруулах, газар өмчлүүлэх, эзэмшигүүлэх, ашиглуулах асуудлыг ил тод, шударга, тэгш явагдаж байгаа болон иргэдэд газартай холбогдсон мэдээлэл хир нээлттэй байгааг судлах, хуулийн хэрэгжилтийг сонгосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд судалж дүгнэлт, зөвлөмжийг гаргах, хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.

Төслийн хүрээнд суурин болон хээрийн судалгаа явуулж, Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын статистик мэдээллийг боловсруулж, дүгнэлт гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа газрын талаархи төрөл бүрийн мэдээллийг цуглуулан мэдээллийн дэд сан байгуулж, тэдгээрт дүгнэлт хийх, сонгосон нэгжид газрын мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулж, шүүх, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагуудад газрын талаар гарсан зөрчил, өргөдлийг хэрхэн шийдвэрлэж буйг судлах, санал асуулга явуулан мэдээлэл цуглуулж судлах, ТББ-аас хийж буй ажлын талаар хэвлэлийн бага хурал, семинар зохион байгуулж, судалгааны үр дүн болон шийдвэрлэх шаардлагатай асуудлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд сурталчлах ажлуудыг зохион байгуулах юм.

Хоёр. Төслийн хүрээнд хийсэн ажлын талаар

Газрын шинэ тгэлийн хэрэгжилтэнд мониторинг хийх зорилгоор 2004 оны 4 сараас эхлэн төслийг хэрэгжүүлж байна. Төслийн эхний 3 сарын хугацаанд дараахи ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэв. Үүнд:

- 2.1. Дугуй ширээний ярилцлага зохион байгуулах;
- 2.2. Санал асуулгаар судалгаа явуулах;
- 2.3. Хэвлэлийн мэдээлэл дээр үндэслэн Газрын мэдээллийн сан байгуулах;
- 2.4. Газрын статистик мэдээнд дүн шинжилгээ хийх;
- 2.5. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах;
 - 2.5.1. Хэвлэлийн бага хурал зохион байгуулах;
 - 2.5.2. Радио, телевизээр мэдээлэх;
- 2.6. Шүүхийн байгууллагад газрын талаар гарсан өргөдөл, гомдлын судалгаа хийх /Баянгол дүүрэг/;
- 2.7. Цагдаагийн байгууллагад газрын талаар гарсан өргөдөл, гомдлын судалгаа хийх /Баянгол дүүрэг/;
- 2.8. Улсын хэмжээний хууль, тогтоомжийн зөрчилд үнэлгээ хийх;

2.1. Дугуй ширээний ярилцлага. Төв болон орон нутгийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, бусад байгууллагын эрдэмтэн, судлаачидтай уулзаж, төслийн талаархи санал бодлыг нь сонсож, хамтран ажиллах талаар дугуй ширээний ярилцлага зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд орон нутгаас газрын асуудал хариуцсан мэргэжилтэн 12, эрдэмтэн судлаач 4 хүн оролцлоо. Газрын шинэлгэлийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, энэ ажилд мэргэжлийн болон бусад байгууллага, иргэдийг татан оролцуулж мэдээлэл авах, хэрэгжилтийн байдлыг хамтран судлахаар тохиролцов.

2.2. Санал асуулга судалгаа. Иргэдээс авах “Газрын шинэлгэл- санал бодол” социологийн судалгааны асуулгыг боловсруулж Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Алтанбулаг, Сүхбаатар сум, нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 400 гаруй иргэнээс 4 чиглэл, 44 асуултын дагуу судалгаа авч дунг нэгтгэв.

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны ажлыг газрын харилцааны бус нутгийн онцлогуудыг болон ашиглалт, эзэмшилт, өмчлөлийн гол чиглэлүүдийг төлөөлж чадах хэд хэдэн районуудыг сонгон авсан бөгөөд Үүнд:

1. Газар тариалангийн чиглэлээр Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум
2. Аймгийн төвүүдийг төлөөлүүлж Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум

3. Чөлөөт бус болгох чиглнлээр төлөвлөж буй Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум
4. Ашигт малтмал олборлолтын чиглэлээр Төв аймгийн Заамар сум
5. Говийн бүсийг төлөөлж Өмнөговь аймгийн Сэврэй сум
6. Тусгай хамгаалалттай газар нутгаас Говь Гурван сайхан, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолбор газруудын орчны бүсийн сум суурин
7. Хүн амын төвлөрлийн гол бус болох нийслэлийн бүх дүүргүүдийг хамруулан судалгааг явуулахаар төлөвлөсөн юм.

Судалгааны асуулт:

Социологийн судалгааны анкетийг


1. Судалгаанд хамрагдагсдын бүрэлдэхүүнийг тодорхойлох асуултууд
2. Газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцаанд хэрхэн оролцож байгааг тодорхойлох асуултууд
3. Газрын шинэ тэтгэлийн бодлогын хэрэгжилтийн байдлыг судлах асуултууд
4. Орон нутгийн онцлогоор ялгавартай авах асуултууд зэрэг 4 чиглэлээр 44 асуулттайгаар боловсруулж, судалгаа явуулах нэгжийн ард иргэдийн нийгмийн бүрэлдэхүүний төлөөллийг бүрэн, жигд хамруулан оролцуулахыг зорилоо. Асуултыг боловсруулахдаа энгийн ойлгомжтой хэлбэрээр тавьж, хариулахад болон дүнг нэгтгэхэд дөхмийг бодож, ихээхэн хэмжээний бичиглэлийн ажил орох нээлттэй асуултаас аль болох зайлсхийлээ.

Судалгааны эхний үе шатны дун: Судалгааны эхний үе шатанд Сэлэнгэ аймгийн Цагаанннуур, Алтанбулаг сумд, Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгийн 400 шахам хүнийг хамруулан, явуулж дүгнээд байна. Судалгаа явуулахын өмнө сумын хүн амын нийгмийн бүрэлдэхүүний статистик үзүүлэлттэй танилцаж тэдний төлөөллийг аль болох жигд тусгахад анхаарсан болно. Судалгааны асуултууд болон түүнийг дан тоололтоор нэгтгэсэн байдлыг тайланда хавсаргасан бөгөөд эхний үе шатны судалгаагаар үнэлэлт дүгнэлт хийж болох гол асуултуудыг түүн авч товч дүгнэлт хийв. Судалгаа явуулахаар сонгосон бүх газарт судалгааг хийсний дараа нэгдсэн дүгнэлтийг хийх шаардлагатай тул энэ удаа нийслэлийн гэр хороололын төлөөлөл болсон Сонгинохайрхан, тариалангийн гол төлөөлөгч болсон Цагаанннуур, Тусгай



хэрэгцээний газрын өвөрмөц төлөөлөл болсон Чөлөөт бүсийн Алтанбулагт сумдын судалгааг үндэслэн урьдчилсан байдлаар зарим нэг дүгнэлтийг хийлгээ.


A. Судалгаанд хамрагдагсдын нийгмийн бүрэлдэхүүн:

Насны байдлаар



- Чөлөөт бүсийн Алтанбулагт сумдын судалгааг үндэслэн урьдчилсан байдлаар зарим нэг дүгнэлтийг хийлгээ.
- 25-45 онд оршин суугчид (25-45 онд оршиж) өвөрмөц төлөөлөл болсон Чөлөөт бүсийн Алтанбулагт сумдын судалгааг үндэслэн урьдчилсан байдлаар зарим нэг дүгнэлтийг хийлгээ.
- 45-60 онд оршин суугчид (45-60 онд оршиж) өвөрмөц төлөөлөл болсон Чөлөөт бүсийн Алтанбулагт сумдын судалгааг үндэслэн урьдчилсан байдлаар зарим нэг дүгнэлтийг хийлгээ.
- 60+ онд оршин суугчид (60+ онд оршиж) өвөрмөц төлөөлөл болсон Чөлөөт бүсийн Алтанбулагт сумдын судалгааг үндэслэн урьдчилсан байдлаар зарим нэг дүгнэлтийг хийлгээ.

Ажил эрхлэлтийн байдалАм булийн байдалБоловсролын байдал



Б. Судалгааны явцаас хийх урьдчилсан дүгнэлт

Судалгааны явцад ажиглагдсан нэг зүйл бол хуулийг батлахын өмнө ард түмний саналыг авах, батлагдсаны дараа өргөн сурталчлах асуудал туйлын хангалтгүй байна. Айл өрх хүн бүрийн амьдралтай салшгүй холбоотой энэ асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хуулийн төсөл боловсруулагчдад ирсэн санал туйлын ядмаг байна. Хууль батлагдсаны дараа түүний мөн чанарыг ард иргээдэд ойлгуулах системтэй ажлыг зохион байгуулахын оронд эрх баригчдыг магтан дуулах сургалтчилгаа болгон хувиргасан байна.

Энэ тухай мэдээллийг огт аваагүй хүмүүс хотод 18.7%, хөдөөд 21% байгаа бөгөөд, хүмүүсийн дам ярианаас мэдээлэл авагсад хотод 18.6%, хөдөөд 14.0% байна. Дам яриа гэдэг бол элдэв цуурхал, гажуудлын эх үүсвэр болдог шүү дээ.

Хүмүүст жинхэнэ хүрэх ёстой ухуулга сургалтчилгааны ажил туйлын чамлалттай байгаа нь асуулгын дүнгээс харагдаж байна. Одоо төрийн албан хаагчдын нүсээр арми ажиллаж байгаа боловч энэ чухал ажлын сургалтчилгаанд

дайчлан зохион байгуулсан харагдахгүй байна. Иргэдийн мэдээлэл авсан байдлыг дараахи хүснэгтэд харуулав.

Хүснэгт-1

Мэдээллийн эх үүсвэр

Мэдээллийн эх үүсвэр	Хотод СХД	Хөдөө АБ, ЦН
а. Телевизээс	36.7	28.6
б. Радионоос	4.3	0.5
в. Сонин хэвлэлээс	7.2	15.7
г. Ухуулга сурталчилгаанаас	5.8	8.6
д. Хүмүүсийн ярианаас	18.7	14.0
е. Хуулийн ном товхимлоос	8.6	9.7
ё. Ямар ч мэдээлэл аваагүй	18.7	21.0

.Газар өмчлүүлэх тухай хуулийг та хэрхэн үзэж байна вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогсод хэрхэн хариулсан байдлыг дараахи байдлаар үзүүлэв.

Газар өмчлүүлэх тухай хуульд судалгаанд

оролцогчдоос өгсөн үнэлэлт

- а. Цаг үеэ олсон хууль сайн хууль болсон 24.4%
- б. Хэрэгжих нөхцөл бүрдээгүй байсан 16.9%
- в. Газрыг гэр бүлд өмчлүүлнэ гэсэн нь иргэдэд газрыг 16.9%
- өмчлүүлэх Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна..... 20.6%
- г. Хугацаа заасан нь хүний эрхийг ноцтой зөрчиж байна. 21.3%

Газрын тухай багц хуулийн талаар иргэдийн өгсөн дүгнэлтийг авч үзвэл хэрэгжих нөхцөл нь бүрдээгүй гэж 16.9% нь, энэ хууль үндсэн хууль болон, хүний эрхийг ноцтой зөрчсөн гэж 41.9% нь үзсэн байна. Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа иргэдийн гол тайлбар нь газрыг иргэдэд бус гэр бүлд өмчлүүлэхээр заасан, газар өмчлөлийн ажлыг 2 жилд багтаан зохион байгуулахаар хугацаа тогтоосон явдал гэж үзэж байна. Тэгэхдээ бидний үзэж байгаагаар хугацаа тогтоосон явдал нь нэг талаас иргэдийг энэ ажилд шуурхай хамруулах гэсэн тактикийн асуудал бөгөөд цаашид энэ хугацааг сунгаж байх бололцоотой юм.

Газар өмчлөлийн асуудлын гол хэсэг бол хот, суурин газруудын иргэдийн оршин суух хашааны газар юм. Судалгаа хийгдсэн дүнгээс үзэхэд одоогоор иргэдийн 20 орчим хувь нь хашааны газраа өмчлөх эрхийн бичгээ

авсан нь харагдаж байна. Мөн өмчлөх хүсэлтээ гаргасан иргэд 20 орчим хувийг эзэлж байна. Хэрэв элдэв чирэгдэлгүйгээр хувьчлах ажлыг зохион байгуулсан бол иргэдийн 40 хувь нь хашааны газраа өмчлөн авах боломж байсан байна. (Тэгэхдээ төрийн албан хаагчдыг өрөөсгөлөөр шүүмжлэх байр сууринаас хандсангүй. Газрын бичиг баримт бүрдүүлэх тэдэнд тайлбарлан ойлгуулах зэрэгт асар их цаг зарцуулж байгаа бөгөөд одоогоор энэ байранд ажиллаж байгаа нэг ажилтанд үйлчлүүлэгчдийн тоо хэт их байгаа нь ажиллагааг хүндруулж байгаа нь харагдаж байна. Иймээс бид судалгааны дараагийн шатанд эдгээр ажилтнуудын ажилд хронометражийн аргаар судалгаа хийж ажлын ачааллын байдлыг нь судлан үзэх нь зүйтэй гэж үзэж байгаа болно)

Хашааны газраа хэрхэн өмчилж авахаа мэдэхгүй иргэд бас нилээд хувийг эзэлж байгаа бөгөөд ялангуяа Сонгинохайрхан дүүргэд 5 хүн тутмын нэг нь тодорхой мэдээлэлгүй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь нэг талаас сурталчилгааны ажил хангалтгүйтэй, нөгөө талаас хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд харьцангуй нэмэгдэж байгаатай холбоотой.

Хүснэгт -2


Хашааны газраа өмчлөх эрхийн гэрчилгээ авсан байдал

Асуулт	Хариулт %-иар		
	СХД	Алтанбулаг	Цагааннуур
а, өмчлөх эрхийн гэрчилгээ авсан	20.7	22.3	24.4
б.Өргөдөл хүсэлтээ гаргасан боловч гэрчилгээгээ аваагүй байгаа	21.6	24.7	6.9
в Хэрхэн хувьчилж авахаа мэдэж байгаа боловч өргөдөл хүсэлтээ гаргаж амжаагүй байна	18.7	22.3	41.8
г Өргөдөл хүсэлтээ хаана гаргаж хэрхэн хувьчилж авахаа мэдэхгүй	23.7	17.6	16.3

д Олон жил амьдраад ирсэн газартаа гэрчилгээ авсан аваагүй байгаад байж болно гэж бодож байгаа	2.9	3.5	5.8
е Орон сууцанд амьдардаг тул өмчлөх газраа шийдээгүй байна	2.9	2.3	3.4
ё. Орон сууцанд суудаг боловч хашааны газар өмчилж авсан.	-	1.1	1.1
Хариулаагүй	8.6	5.8	-

Судалгааны явцад хашааны газрын ашиглалтын байдалд бид зохих анхаарал тавив. СХД-ийн гэр хорооллын 75.9 хувь нь хашаандаа байнга аж төрдөг бөгөөд 5 хашаа тутмын нэгд 2-өөс дээш өрх оршин суудаг байна. Эзэн нь хашаандаа байнга оршин суудаггүй хашаа 6 хувийг эзэлж байна. Эдгээрийн 68.3 хувь нь эзэнгүй, 32.7 хувь нь сахиул буулгасан байна.

Хашааны газрын ашиглалтын байдал /СХД/



Тайлбар:

- Хашаанд нэг өрх айл байнга суудаг (51.4%)
- Хашаанд айлууд хамт аж төрдөг (24.5%)
- Эзэнгүй байгаа хашаа (4.1%)
- Сахиул айл буулгасан хашаа (1.9%)
- Бусад (4.1%)
- Хариулаагүй (14.1%)

Хашааны хэмжээний байдлыг хот хөдөөгөөр харьцуулан үзвэл хуульд заасан хэмжээнээс бага хэмжээний хашаатай айл хотод 57.1%, хөдөөд 35.9 хувь байхад заагдсан хэмжээнээс том хашаа хотод 24.3%. хөдөөд 60% байна.

Хүснэгт -3

Хашааны хэмжээ /Хариулсан хүмүүсээс %-иар/

Хашааны хэмжээ	СХД	Алтанбулаг
Хуульд заасан хэмжээнээс бага	57.1	35.9
Хуульд заасан хэмжээнд	18.6	5.1
Хуульд заагдсан хэмжээнээс том	24.3	60.0

Хашаагаа цаашид хэрхэн захиран зарцуулах байдлыг аөч үзвэл 60.2 хувь нь байнга оршин сууж үр хүүхдэдээ өвлүүлэх, 20.7% нь ямар нэг хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулах, 19.1 % нь тодорхой төлөвлөсөн зүйлгүй байна.

Хашааны газраа цаашид хэрхэн захиран зарцуулах

- а. Байнга хашаандaa амьдран сууж үр хүүхдэдээ өвлүүлнэ 60.2%
- б. Барьцаалж зээл авах бодолтой 9.0%
- в. Худалдана 6.3%
- г. Айл буулгаж түрээслэнэ 3.1%.
- д. Болж өгвөл гадаадын иргэнд ахиухан хөлсөөр түрээслэнэ 2.2%
- г. Төлөвлөөгүй 19.1%

Тариалангийн талбайн үржил шим буурах, элэгдэл эвдрэлд орох замаар эдэлгээсээс гарах явдал газар тариалангийн үйлдвэрлэлийн анхаарал татсан асуудал бөгөөд тариалангийн талбайн үржил шимиийн байдал ноцтой хэмжээнд буурсан гэсэн дүгнэлттэй судалгаанд оролцогчдын дийлэнхи буюу 90.6% нь санал нийлж байна. Тэгэхдээ тэдний 59.3 хувь нь үржил шимиийн доройтол нийт талбайд биш алаг цоогтой байгаа хэмээн үзжээ. Энэ нь

Тариалангийн талбайн үржил шим 60-70%-иар буурсан гэсэн
дүгнэлтийг хэрхэн үзэж байгаа /Цагааннуур сум/
а. Арай ч үгүй байх 9.8%

б. Санал нийлнэ	36.9%
в. Алаг цоогтой байгаа	53.7%

Судалгааны дүнгээс үзэхдээд тариалангийн талбай эзэмшиж ашиглаж байгаа хүмүүсийн газар ашиглалтын байдал хангалтгүй байна. Тухайлбал нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт тариалангийн газар эзэмшиж буй хүмүүсийн 35.3% нь талбайнхаа хагаст нь тариалалт хийсэн, 44.1% нь талбайгаа огт ашиглаагүй, 5.9% нь бусдад түрээслүүлсэн байна. Газар тариалангийн гол бус нутаг болох Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Цагааннуур сумдад эзэмшиж, ашиглаж буй талбайдaa бүрэн тариалалт хийсэн иргэн дөнгөх 16.4-12.9%-ийг эзэлж байна. Тариалангийн талбайг ашиглахгүй амаржуулах нь түүний чанарыг доройтуулах нэг шалтгаан болдог тул талбайг бүрэн тэгэхдээ үр бутээлтэй ашиглауулах тодорхой хөшүүргийг бий болгох шаардлага ч байна гэж үзэж байгаа болно.

Хүснэгт-4

Тариалангийн талбай эзэмшиж буй хүмүүсийн талбайн ашиглалт

Талбай ашиглалт	СХД	Алтанбулаг	Цагааннуур
Бүх талбайд тариалалт хийсэн	14.7	12.9	16.4
Хагаст нь тариалалт хийсэн	35.3	48.4	23.6
Одоогоор ашиглаагүй	44.1	32.2	25.4
Түрээслүүлсэн	5.9	6.5	34.5
Хүний тоо	34	31	55

Тариалангийн талбайг хэрхэн өмчлүүлэх нь зүйтэй вэ гэсэн асуултад өрхөөр нь буюу гэр бүлээр нь өмчлүүлэх хэлбэрийг зүйтэй гэж үзсэн иргэд хамгийн олонхи буюу 58.8% -ийг эзэлж байна

Тариалангийн газрыг өмчлүүлэх
/Цагааннуур, Алтанбулаг сумдын/

а. Иргэнд	27.8%
б. Өрхөөр	31.0%
в. Аж ахуйн нэгжид	10.0%
г. Хэсэг бүлэгт	8.3%

Хувиараа жижиг талбайд тариалан эрхлэгчид цаашид ямар зохион байгуулалтаар ажиллах нь илүү үр дүнтэй вэ? /Бүх газар/	
а. Өөр өөрийн талбайдаа бие дааж ажиллах.....	13.1%
б. Талбайгаа нэгтгэж томоохон аж ахуй нэгж байгуулах	9.4%
в. Талбайгаа тус тусдаа эзэмшиж, хүч хөдөлмөр,	
техник тоног төхөөрөмжөө хоршин ажиллах	22.5%
г. Үр ашигтайгаар түрээслүүлэх	7.5%
д. Өөр ямар	0.6%
Хариулаагүй	46.8%

Тариалангийн талбайг өрх гэрээр эзэмшиүүлэх зохион байгуулалтын дүнд асар олон жижиг тариаланчид буй болох ба түүнтэй холбогдож чамгүй бэрхшээл тохиолдох бөгөөд түүнийг хэрхэн даван туулах талаар тэдний саналыг судалсан юм. Тэгэхэд тэдний тал шахам буюу 46.8% нь асуултад тодорхой хариулт өгөөгүй нь энэ талаар ямар нэгэн зүйлийг бодож төлөвлөөгүй гэсэн уг. Харин 22.5% нь хүч хөдөлмөр, техник тоног төхөөрөмжөө хоршин ажиллах бодолтой аж. Тэрчлэн 13.1% нь бор зурхээрээ хувна борлуулж довоо шарлуулах зарчмаар бие даан ажиллах бодолтой байна. Цагаан нуур сумд хийгдсэн нэгэн сонин хувилбар нь том аж ахуйн нэгжийн талбайг ажиллагсадад нь хуваан эзэмшиүүлж тэдгээр нь компанидаа талбайгаа түрээслүүлэх зарчмаар ажиллаж байгаа явдал юм.

Жижиг тариаланчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн хувьд бага оврын техник хэрэгслээр хангах, хөл дээрээ бостол татварын хөнгөлөлт үзүүлэх, газрыг барьцаалж хөнгөлөлттэй зээл олгох асуудалыг голчлон хөндсөн байна. Харин тэд арга технологи эдийн засгийн сургалт явуулах гэсэн асуултад нэг их анхаарал тавиагүй нь нэг талаас арга технологийн зохих бэлтгэлтэй болсон гэж үзэх үндэстэй ч нөгөө талаар манайхны ийм чухал асуудалд хайнга ханддагийг ч бас харуулж байна гэж хэлж болно.

Жижиг тариаланчдад төрөөс ямар дэмжлэг үзүүлэх

- а. Аж ахуй эрхлэх арга, эдийн засаг, менежмент,
технологийн сургалт явуулах 4.7%
- б. Бага оврын техник хэрэгслээр хангах 20.0%
- в. Газрыг нь барьцаалж хөнгөлөлттэй зээл олгох 14.1%
- г. Хөл дээрээ бостол татварын хөнгөлөлт үзүүлэх 16.3%
- д. Өөр ямар 1.3%.

Алтанбулаг сумд чөлөөт бүс байгуулах асуудал эртнээс яригдаж олон айл өрх шилжин ирж тэр “Сайхан цаг”-ийг тэсэн ядан хүлээж байгаа боловч энэ асуудал удааширч цаашдаа хэр үр дүнтэй болох нь эргэлзээтэй болж байна. Чөлөөт бүс нь тусгай хэрэгцээний газрын категорт хамрагддаг бөгөөд ийм нөхцөлд газар өмчлөх асуудалд ч зарим бэрхшээл учрах төлөөв байдал харагдаж байна. Ярилцлага судалгааны байдлаас харахад иргэдийн итгэл найдвар үндсэндээ цөхрөлтийн байдалд ороод байна.

Энэ судалгаанд төслийн ажилтнууд болон Эко-Ази ДС-ийн оюутнууд оролцож ажилласан. Судалгааны эцсийн дүгнэлтийг судалгаа бүрэн авсны дараа гаргах бөгөөд тодорхой саналуудыг хөндөн тавих болно.


2.3. “Хэвлэлийн нийтлэл” мэдээллийн сан. Газрын шинэ тгэлийн асуудлаар сүүлийн 5 жилд өдөр тутмын сонинуудад гарсан материалыг /1999 оноос хойш/ нэгтгэн анализ хийх зорилгоор “Хэвлэлийн нийтлэл” мэдээллийн сан байгууллаа.

Мэдээллийн сангийн бүрэлдэхүүн

Мэдээллийн санд Улс төрийн зүтгэлтэн, УИХ-ын гишүүн 38 хүн, эрдэмтэн судлаачид 18, олон нийтийн байгууллага 6, газрын албаны мэргэжилтэн 15, сөрөг намууд 3, гадаадаас МУ-д сууж буй элчин сайд 2, иргэн 144 хүний санал хүсэлт, үзэл бодол, дүгнэлтийг хамруулан оруулсан болно.

Мэдээллийн сан нь мэдээллийн товъёог, 270 хуудас дэлгэрэнгүй мэдээлэл болон 80 хуудас /хүснэгтээр/ товч мэдээллээс бүрдэж байна. Эдгээр мэдээллийн эх хувь нь “Байгаль 21” ТББ-ын санд файл болон тусгай хавтаст хэргийн хэлбэрүүдээр хадгалагдаж байгаа болно.

I юүйёөдөр нийтийн ажлыг хөгжүүлэх



Товъёог болон товч мэдээллийн загварыг энд үзүүллээ.

Хүснэгт-5

Мэдээллийн сангийн товъёог

№	Сонины нэр	Огноо	Нийтлэгчийн нэр	Агуулга	Тайлбар
5.	Өнөөдөр №134	2002.4.6.	УИХ-ын хаврын чуулганы нээлт	Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах цаг болсон	МУ-ын ерөнхийлөгч Н.Багабандийн хэлсэн угнээс

Хүснэгт-6

Газрын тухай товч мэдээлэл

№	Ангилал	Үзэл бодлын товч утга	Сонины нэр, дугаар	Газрын мэдээлэл /худасны дугаар/
Нэг. МУ-ын ерөнхийлөгч, төрийн зутгэлтнүүд, УИХ-ын гишүүдийн үзэл бодол				
1.	Н.Багабанди	УИХ-ын хаврын чуулганы нээлт: “Шинэлэлийг зоригтой бөгөөд ухаантай хийхээс өөр сонголт үгүй”. Газар өмчлөл чүнд хамаарна. Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах цаг болсон.	өнөөдөр №134 2002.4.6	76

Мэдээллийг Газрын тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдахаас өмнөх болон батлагдсанас хойших үе гэж ангилан нэгтгэлээ.

2000 онд байгуулагдсан МУ-ын ЗГ-аас Газар өмчлүүлэх талаар
авсан арга хэмжээ

Газар өмчлөлийн асуудал - Үндсэн хуульд өрөнхий зарчим нь тусгагдсанаас эхлэн өнөөг хүртэл нийт иргэдийн анхаарлын төвд байж, улс төрийн бүх хүчний бодлого, сурталчилгааны байнгын сэдэв болсоор ирсэн билээ.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд манай улс газрын талаархи эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудалд анхаарлаа хандуулж байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд төрийн өмчийн газрыг эзэмших, ашиглахтай холбогдсон “Газрын тухай” хуулийг 1994 онд, төрийн өмчийн газрын төлбөрийн талаархи харилцааг зохицуулсан “Газрын төлбөрийн тухай” хуулийг 1997 онд, газрын кадастрын харилцааг зохицуулсан “Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай” хуулийг 1999 онд тус тус батлан гаргаж хэрэгжүүлж ирсэн байна..

2000 онд байгуулагдсан МУ-ын Засгийн газар Газрын шинэ тгэлийг эрчимжүүлэх зорилт тавин энэхүү арга хэмжээний хүрээнд газар эзэмших эрхийг өргөтгөж, газрын харилцааг зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгох, газрын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тэдгээрийн эрх үүргийг тодотгоход чиглэсэн “Шинэчлэн найруулсан Газрын тухай” хууль, Монгол улсын иргэдийн газар өмчлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулиудыг болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээний тогтоол, журам, заавар, аргачлалыг батлан гаргаад хэрэгжүүлж байна.

Газар эзэмшүүлэх, өмчлүүлэх бэлтгэлийг 2003 оны наана хангах бололцоо бий гэж төр, засгаас үзсэн байна.

УИХ, ЗГ 2003 онд газрын шинэ тгэлийг эрчимжүүлэх, Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд бодлого, үйл ажиллагааны олон талт арга хэмжээ авсан ба өнгөрсөн онд хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон 40 орчим журам, аргачлал батлан мөрдүүлсэн байна.

“МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийг хэлэлцүүлэх бэлтгэл ажил болгон УИХ-ын дарга, гишүүд, ерөнхий сайд, засгийн газрын гишүүд, эрдэмтэн мэргэдийг оролцуулсан өргөн хэмжээний семинарыг 2 удаа зохион байгуулж, УИХ-ын гишүүд, ард иргэд, байгууллагуудаас ирүүлсэн зарчмын зөрүүтэй 118 саналыг нэгтгэн цэгцэлжээ.

Газар өмчлүүлэх хуулийг хэрэгжүүлэх талаар аяч явгуулсан арга хэмжээ

МУ-ын түүхэнд тэмдэглэгдэн үлдэх үйл явдлыг анх удаа МУ-ын засгийн газар 2003 онд хийв. Энэ нь МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, батлуулж, иргэддээ газрыг үнэ төлбөргүйгээр хувьчилж өгсөн явдал юм.

Энэ хуулийг 2003 оны 1-р сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөх бөгөөд иргэдэд гэр бүлийнх нь хэрэгцээнд зориулж нэг удаа үнэгүйгээр газар өмчлүүлэх ажлыг 2003 оны 5-р сараас эхлэн 2 жилд багтаан хэрэгжүүлэхээр уг хуульд заасан.

Манай улсын 156.4 сая га нутаг дэвсгэрийн дотор Үндсэн хууль иргэддээ өвлүүлж болохоор заасан доорхи ангиллын газар байгаа юм. Үүнд:

Хот суурин газрын гэр хороололд оршин суугчдын хашаа, орон сууцны доорхи газар	20.6 мян/га
--	-------------

Айл өрхийн хувийн хэрэгцээндээ зориулж тарьсан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, бусад таримлын доорхи газар	24.5 мян/га
--	-------------

Аж ахуйн нэгж, байгууллагуудын доорхи байршлын газар	11.3 мян/га
--	-------------

Тариалангийн зориулалтаар ашиглагдах газар	1189.9 мян/га
--	---------------

Бүгд	1246.3 мян/га
------	---------------

Энэ нь манай нутаг дэвсгэрийн 0.9 орчим хувь юм.

Үүнээс эхний ээлжинд үнэгүйгээр хот суурин газарт оршин суугчдын хотын ба зуслангийн хашаа, гэр, байшин, орон сууцны доорхи 20.6 мян/га газар буюу улсын хэмжээний нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 0.01% нь иргэдийн хувийн өмчлөлд шилжих юм байна.

21 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 522,7 мянган га газрыг иргэдэд өмчлүүлэх шаардлага байгаа бөгөөд үүний 75% буюу 392,6 мянган га нь одоо эзэмшиж ашиглаж байгаа газар, 25% буюу 130 мянган га нь нөөц газар байна. Одоо эзэмшиж ашиглаж байгаа газрын 167,9 мян/га-г гэр бүлийн хэрэгцээний,

7654,5 га-г аж ахуйн хэрэгцээний, 337,5 мян/га тариалангийн талбай, 9387,3 мян/га атаршсан газрыг газар тариалангийн зориулалтаар өмчлүүлэх юм.

Монгол Улсын 558065 өрх, гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүйгээр газар өмчлөх эрхтэй боллоо.

Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2004 оны 2-р сард газар өмчлөлийн явц, байдлыг хэлэлцэж уг ажлыг хуулийн дагуу хэвийн явагдаж байна гэж үзэж, хуулийн хэрэгжилттэй холбогдсон тодорхой асуудлаар холбогдох байгууллагуудад зөвлөмж өгсөн байна.

Үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар газар өмчлүүлэх ажлын хүрээнд хийгдсэн бэлтгэл ажлыг хэлэлцэж, газар өмчлөлийн ажлыг зохион байгуулах календарчилсан төлөвлөгөөг баталсан байна.

Газар эзэмших, ашиглах, өмчлөлийн ажлыг хэрэгжүүлэхээр цомхон бүтэцтэй Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. Газрын тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэл, дүүргүүдэд газрын алба байгуулагдсан, харин сумдад газрын даамал ажиллах боловсон хүчин, хөрөнгө, төсөв одоогоор шийдэгдээгүй байгаа тул Байгаль орчны байцаагч, Тамгын газрын дарга нарт энэ албыг түр хавсруулан ажиллуулж байгаа ажээ.

Шведийн Shwedsurvei байгууллагатай газар ба үл хөдлөх хөрөнгийн мэдээллийн санг нэгтгэх, мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх чиглэлээр Европын холбоотой хамтран сургалтын төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа юм байна.

“Газрын бирж” болон Кадастрын бүртгэлийг нэгдсэн тогтолцоо бий болгох талаар Германы мэргэжилтэн сургалт зохион байгуулжээ.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл болон улсын газрын мэдээллийн сан байгуулах ажлын хэсгийг агентлагийн даргын тушаалаар ажиллуулж байна.

Газар өмчлүүлэх хянан баталгааны ажилд нийслэлийн төсвөөс 30, зөрчилтэй хашааг шинэ суурьшлын бүс рүү нүүлгэхэд 50 сая төгрөгийг гаргахаар болжээ.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл болон улсын газрын мэдээллийн сан байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд 42713 иргэн газраа өмчилж авах хүсэлт гаргаснаас 30706 иргэнд 2069.39 га газрыг өмчлүүлж, газар өмчлөлийн явц

төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад улсын хэмжээнд 17.5 хувь, үүнээс нийслэлд 42 хувь, аймгуудад 6.5 хувьтай байна.

УИХ-ын гишүүд, улс төрийн зутгэлтнүүдийн узэл бодол

МУ-ын ерөнхийлөгч Н.Багабанди - УИХ-ын хаврын чуулганы нээлт дээр хэлсэн үгэндээ: Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах цаг болсон. Газрын асуудлыг нэн эмзэг, нухацтай бodoх, бүх нийтийн саналыг харгалзан шийдэх асуудал мөн. Гэхдээ түүний үр шим өгөөж, хэвлийн баялгийг зүй зохистой ашиглах, бас нөхөн сэргээх, хамгаалах, аж ахуйг эрхлэн тогтвортой үйлдвэрлэл явуулахын тулд Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгосон энэ асуудлыг хойшлуулах цаг хугацаа үлдээгүй шүү гэдгийг зориуд онцлон хэлье гэсэн байна.

Ерөнхий сайд Н.Энхбаяр - УИХ-ын хуралдаан дээр Иргэнд газар өмчлүүлэх нь улс төрийн хүчний том ололт болно гэлээ.

МУ-ын анхны ерөнхийлөгч П.Очирбат – УИХ-д ирүүлсэн илгээлтдээ Монгол орны хувьд газар харьцангуй давуу талын нэг, хамгийн үнэтэй капитал бөгөөд иргэний өмчийн бусад эд юмсыг байрлуулах орон зай, хүн амын суурьшсан амьдрах орчин юм. Газрын тухай хууль нь газартай холбогдсон харилцааг зохицуулах суурь хууль учраас Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд газар эзэмшүүлэх, ашигуулахаас гадна өмчлүүлэх асуудал тусгагдах ёстой гэж хэлжээ.

УИХ-ын олонхи гишүүд: Газрыг хувьчлах нь зүйтэй. Ингэснээр газар эдийн засгийн эргэлтэд орох хууль зүйн үндэс бүрдэж, иргэдийн газар, газар дээрхи байшин, барилга байгууламжаа хамтатган өмчлөх эрх нь баталгаажиж, өмчлөн авсан газар, түүн дээрхи үл хөдлөх эд хөрөнгөө бусдад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах эрх бүрэн хангагдана гэсэн саналтай байна.

Харин зарим сөрөг нам, гишүүд /ИЗ-БНН, С.Оюун/ - Газрын болон газар өмчлүүлэх 2 хууль гарсныг иргэд сайн ойлгохгүй байна. Газар өмчлүүлэх хуулийг 10-хан хоногт хэлэлцэж маш түүхий гаргасан. Засгийн газар иргэдийн байтугай парламентийн цөөнхийн үгийг сонсоогүй, ерөнхийлөгчийн байр суурийг ч хүлээж аваагүй гэсэн эсрэг байр суурьтай байлаа.

Нэг хэсэг нь /Л.Гүндалай/ - Бага газартай тариаланчид энэ салбарыг үр дүнтэй авч явдаг нь батлагдсан зүйл. Жижиг фермерийг бий болгохгүйгээр газар тариалан хөгжихгүй. Ийм үед газраа иргэдэд хүргэх ёстой гэж байхад, нөгөө хэсэг нь /Р.Содхүү, М.Далайхүү, Н.Тогтох, Ж.Гомбожав/ газрыг яaran хувьчлах шаардлагагүй, түрээслүүлэх нь зөв, урдах хуулиа яаж хэрэгжихийг мэдээгүй байж энэ хуулийг ярих нь дэмий, төслийг сайжруулах хэрэгтэй, буцаая гэсэн үзэл бодолтой байлаа.

Эрдэмтэн, судлаачдын дүгнэлт

Байгаль орчныг төвлөрсөн аргаар хамгаалахаас татгалзаж, байгаль ашигласны төлбөрөөр нөхөн сэргээх ажилд анхаарлаа хандуулж, байгалийн өгөөжийг хойч үетэйгээ тэнцүүхэн хувааж ашиглана гэсэн зарчмыг байгаль хамгаалах чиг бодлого болгон барих шаардлагатай. Манай орон цөлжилтийн яг ирмэг дээр байна. /Ц.Адъяасүрэн/

Заг, харгана, шавгийг нь сүйтгэснээс болоод эх нутгийн экологийн төрх төлөв алдагдаж элсний нүүлт ихсэж, хөрс бэлчээрийг хучин дарж байна. /Т.Дамдин/

Монгол-Туркмений цөл судлаачдын 1990 оны дүгнэлтээс үзвэл Монгол орны гандуу хуурай нутгийн 9%-д салхины идэгдэл, 46%-д усны идэгдэл, 45%-д ургамлын нөмрөгийн алдрал болсон ба нутгийн 87% нь сул цөлжилттэй, 11% нь дунд зэргийн , 2% нь хүчтэй цөлжилттэй гэж гарчээ..

Тариачдын сонирхол нь хувийн өмчийн газар бөгөөд.үйл ажиллагааг нь фермерийн тухай хуулиар зохицуулж болох юм..Газрын асуудлыг буруу шийдвэл газар мөлжлөгийн хэрэгсэл болж хамжлагын ядуу тариачны нийгмийн давхарга бий болно. Зөв шийдвэл газар-хөгжлийн эх булаг болж дундаж орлого, амьдралтай мэргэшсэн тариачны давхарга бий болох нөхцөл бүрдэнэ. /Л.Алтангэрэл/

Нутгийнхаа тодорхой хэсэг газрыг ОУ-ын хууль, журмын дагуу харийн оронд удаан хугацааны түрээсээр ашиглуулах нь илүү үр дүн өгнө гэж бодох юм. Тендер зарлавал дэвсгэр нутгийн 0.013%-ийг өзлэх бөгөөд энэ нь ашиглалтгүй өчүүхэн нутаг юм./О.Шагдарсүрэн/

ХАА-н эдэлбэр газруудыг эзэмшүүлэх замаар ашиглуулах нь зүйтэй. /Ц.Дэмбэрэл/

Манай орны газрын шинэлгэл нь бэлчээрийн мал аж ахуйн сууринд тулгуурласан газар тариалан, суурин соёл иргэншлээ тусгасан хэв загвартай байх ёстой. /О.Хадбаатар/

Төв, Завхан, Говь алтай аймагт хийсэн судалгаанаас үзвэл 300 орчим малчин өрхөөс 35-45% нь өөрийн гэсэн өвөлжөө хаваржаагүй гэсэн мэдээ гарчээ./А.Энх-амгалан/

Хөрсний ялзмагийн хэмжээ ашигласан жил, хөрсний эвдрэл, таримлын төрөл бүрийн бусад хүчин зүйлээс шалтгаалж жилд дунджаар 1.0-6.0 тонн гагаар алдагдаж байна. Одоогоор манай орны 600 гаруй мянган га тариалангийн талбай хөрсний эвдрэлд оржээ/С.Долзодмаа/.

Жирийн иргэдийн санал бодол

Сүүлийн жилүүдэд олигтой ургац авч чадаагүй гол шалтгаан нь хүний үйл ажиллагаанаас үүссэн хөрсний доройтлоос болсон. Эзэмшүүлэх, түрээслүүлэх, ашиглуулах талбайн үнийг өндөр тогтоо замаар их хэмжээний газар хагалж, сүйтгэхээс хамгаалах арга хэмжээг яаралтай авах нь зүйтэй. /Хан-уул дүүргийн 2-р хорооны иргэн Ж.Цэнд/

Маш нарийн механизм, зохицуулалтаар газрыг хувьчилж болох юм. Гэхдээ нийт ард иргэдэд адил тэгш хуваарилах хэрэгтэй. Газар гэдэг чинь өөрөө үнэт зүйл, хөрөнгө. Газрыг хувьчилбал өөрийн хөрөнгөө үр өгөөжтэй, үнэ цэнийг гаргаж ашиглах байх. Газартай болсноор хүмүүс газар эзэмших, түрээслэх аргад суралцана. Газар, хүн 2 илүү ойртоно. Одоо эзэмшиж буй газрыг тэр чигээр нь өгсөн нь дээр, хэрэгцээнийх нь хирээр хувьчлах нь зүйтэй гэж ихэнхи хэсэг нь дэмжиж байхад, нөгөө хэсэг нь газрыг яaran хувьчлахын хэрэггүй. Улс орны тусгаар тогтолцоулж алдагдана. Билчээрийн маргаан гарна. Ард иргэдэд ашиггүй хувьчлагдана гэсэн эсрэг саналууд ч гарч байна.

Зарим нь фермерийн аж ахуй эрхлэгчдэд газрыг нь түрээслүүлээч, эхний ээлжинд газрыг түрээслүүлж үр шимийг үзсэний дараа хувьчилж болох юм, ашиглах биш эзэмших сонирхолтой байна гэсэн санал бодолтой байна.

Мөн нэг хэсэг нь монгол хүн хувьчлаад авлаа ч цаана нь харийн хүн, манай газар дээр улс орны эрх ашиг, хүн амын эрүүл мэндэд хор нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулбал яах вэ гэсэн болгоомжлол ч байна.

Хятад, Тайландыг Англид 50 жил түрээслүүлсэн шиг хэсэг газрыг гадаадынханд түрээслүүлж газрынхаа ашиг шимийг хүртэж, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, ард түмнийхээ аж байдлыг дээшлүүлэхэд манайд алдах юмгүй гэсэн санал ч гарч байна.

Малыг малчдад, орон сууцыг хотынхонд хувьчилсан шиг тариалангийн талбайг тариачдад давуу эрхээр хувьчлах нь зүйтэй гэсэн санал бас байна.

МУ-ын үндсэн хуулинд газрыг иргэнд өмчлүүлнэ гэсэн заалт, газар өмчлүүлэх хуулийн газрыг гэр бүлийн хэрэгцээнд дунд нь өмчлүүлнэ гэсэн заалттай зөрчилдсөнөөс, гэр бүлээ бүртгүүлээгүй хүмүүс, гэр бүлгүй залуучууд, 2002.6.28-наас хойш гэр бүлээ бүртгүүлсэн хүмүүс газар өмчлөх эрхгүй болж байна. Зөвхөн гэр бүлд нь өмчлүүлнэ гэвэл 828.9 мянган иргэн газар өмчлөх эрхгүй болохоор байна гэж залуучууд санал бодлоо илэрхийлж байна..

Олонхи нь ард түмэнд ашигтай, амьдралд нь нэмэр болох талаас нь цоорхойгүй сайн хууль боловсруулаасай. Цөөн хүнд ашигтайгаар бүү эргүүлээсэй .Газар өмчлүүлэх асуудлыг бүх ард түмний санал асуулгаар шийдээсэй.гэсэн хүсэл бодолтой байна.

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш газар өмчлөх талаар гарч байгаа

маргаан, зөрчил

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд иргэдэд газар өичлүүлэх ажлын 50 хувийг хийсэн байх ёстой байтал улсын хэмжээнд 17.5 хувь, үүнээс нийслэлд 42 хувь, аймгуудад 6.5 хувьтай байгааг зарим эх сурвалж үгүйсгэж, энэ тоо бол иргэдээс гаргасан өргөдлийн хувь хэмжээ болохоос газар өмчлөлийн явцын бодит тоо биш, улсын хэмжээнд газар өмчлөлийн явц 10 хувиас хэтрээгүй гэсэн шүүмжлэл гарч байна.

Газар өмчлөлийн явцад гарч буй гол маргаан зөрчлүүдийг судалж үзэхэд: Газрын албаныхны зүгээс иргэдийн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэхгүй удаах, олон дахин нааш цааш нь явуулах, албан тушаалаа ашиглан танил талдаа ногоон бүсэд газар олгох, хашааны үнийн зөрүү газраар бизнес хийх, газар давхцуулан олгох, орон сууцны байрны дундах хүүхдийн тоглоомын талбай, амралтын талбайд газар олгох зөрчлүүд дийлэнх байна. Энд нэг жишээг дурдахад: 12 дугаар хороолол 21-р байрны оршин суугчдаас зай болгонд барилга барьж, газар доорхи шугам сүлжээн дээр таардаг, орон сууцнуудын

цонх хаалгыг хаагаад барьчихдаг, хүүхдийн тоглоомын талбай болон хөгшид настны салхи амсдаг орон зайл уустгаад босгочихдог гэсэн гомдол гарч, мэргэжлийн 4 байгууллагаас нийслэлийн удирдлагуудад хандаж энэ шалтгааныг дурдсан хүсэлт гаргажээ.

Гэтэл 21 дүгээр байрны урд иргэн Б.Даваадоржид үйлчилгээний барилга барихаар нийслэлийн Засаг даргын захирамж гарч барилга баригдсаар байна. /Монголын мэдээ №34. 2004.2.19/

Ард иргэдийн зүгээс өөрсдөө хашаагаа дур мэдэн тэлэх, орц гарцыг таглаж хашаа, барилга барих, зөвшөөрөлгүйгээр дур мэдэн хашаа хатгах, өндөр хүчдэлийн шугам дор болон үерийн аюултай орчинд суурьших зэрэг зөрчлүүд давамгайлж байгааг дараах баримтаас харж болно. Үүнд: Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт хийсэн тооллогын дүнгээс үзэхэд Чингэлтэй дүүрэгт тоологдсон хашааны 66,31% буюу 8176 нь ямар нэгэн зөрчилтэй, ямар ч зөвшөөрөлгүй өрхүүд 454 гарсан байна. Мөн зөвшөөрөлгүй буусан 4816, холбооны шугам дээр буусан 2220, цэвэр усны шугам дээр буусан 385, үерийн зам дээр 2079 , цахилгааны өндөр хүчдэлийн дор буусан 1485 хашаа бүртгэгдэж, .Сүхбаатар дүүрэгт 6142 хашаа тоологдоноос 736 нь ямарч зөвшөөрөлгүй, 762 нь хориглосон газар буусан зэрэг зөрчил илэрсэн байна. /Баримтыг нийслэлийн нэг жилийн ажлын тайлангаас авлаа./

Хүний эрхийн үндэсний комиссын мэдээлэл

Хүний эрхийн үндэсний комиссоос Газар эзэмших, өмчлөх эрхийн төлөв байдлын талаар хийсэн судалгааны дүнгээс /Төрийн мэдээлэл. №24. 2004 он./ үзэхэд:

Газрын тухай хуульд иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдлийг ямар хугацаанд шийдвэрлэхийг заагаагүй нь тэднийг ихээхэн чирэгдүүлэх, хүнд суртал үүсэх нөхцөл болдог ба хугацаа маш их сунжирч удааширдаг байна. Тухайлбал, судалгааны явцад “Барилга” корпораци техникийн нөхцөлөө бүрдүүлэх гээд 5 сар гаруй хугацаа зарцуулсан тухайгаа ярьж байсан байна.

Газрын тухай хууль анх 1994 онд батлагдсанаас хойш нийслэлийн төвийн дүүргийн шүүхүүдээс газартай холбогдох нийт 65 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Хэргийг маргааны төрлөөр нь авч үзвэл: газар чөлөөлүүлэх хэрэг 13 буюу 21.3%, албадан нүүлгэх 32 буюу 52.4%-ийг эзэлж байжээ..

Газар ашиглах харилцаанд гарч буй сөрөг үзэгдэл нь ашиглах эрхийн гэрээг богино хугацаатай байгуулдаг тул иргэн, хуулийн этгээд техникийн нөхцлөө бүрдүүлж, зөвшөөрөл авч амжихгүй гэрээний хугацаа нь дуусдаг байна. Дахин сунгах хүсэлт тавихад Газрын алба татгалзсан хариу өгдөгөөс иргэн хуулийн этгээд эрхээ хамгаалулахаар шүүхэд хандах явдал харьцангуй нэмэгдэж байгаа нь ажиглагдсан байна.

Нийслэлийн төвийн 6 дүүргийн нийт 250 оршин суугчдын дунд газрын харилцаа, газар өмчлөх, эзэмшихтэй холбоотой асуудлаар судалгаанд оролцогчдын 57.6% нь газрын асуудлаар ямар нэгэн байдлаар захиргааны байгууллагад хандаж байжээ.

Иргэд газартай холбоотой мэдээллийг олж авах, эрхээ эдлэхийн тулд лавлагаа, зөвлөгөө авахад их анхаардаг болсон байна.

Хүссэн мэдээллээ авч чадаагүй шалтгаан юу вэ? гэхэд 4.8% нь мэдээлэл төлбөртэй байсан, 23.6% нь дараа ир гэж хойшлуулсан, 28.4% нь дутуу дулимаг хариулт өгсөн гэж хариулжээ.

/Засгийн газрын 2003.9.17-ны өдрийн №205 тогтоол/ Захирамжийн хуулбар хуудас тус бүр 200 төг, баталгаажилтын схем хуудас тус бүр 1000 төг, зурган мэдээлэл нэгж талбар бүр 2500 төг гэж тогтоосон нь иргэдэд бэрхшээлтэй байгаа юм байна.

Судалгааны явцад Та газраа өмчилж аваагүй шалтгаан юу вэ? гэхэд 14.4% нь зав хомс байна, 21.2% нь газрын татварын зохицуулалт хийгдэхийг хүлээж байна, 13.2% нь газар эзэмших эрхийн гэрчилгээ зөрчилтэй байгаа, 21.6% нь энэ асуудал зүгширч тогтворжихийг хүлээж байна, 2.4% нь өмчилж авахыг хүсэхгүй байна гэж хариулжээ.

Үүнээс үзэхэд газар өмчлөх ажил маш их чирэгдэлтэй явагдаж байгаагаас иргэд бэрхшээж, болгоомжилж, удааширч байгаа нь харагдаж байна.

Иргэдэд газар өмчлүүлэх ажил Нийслэл, Булган, Дархан уул, Сэлэнгэ аймагт дараах байдалтай байна.

Хүснэгт-7

№	Аймаг, нийслэл	Гэр бүлийн тоо	2003 онд өмчлүүлэх газрын хэмжээ	2003.12.31-ний байдлаар өмчлүүлсэн газар	Газар өмчлөх боломжтой нийт гэр бүлийн дотор өзлэх хувь
1.	Улаанбаатар хот	129252	4586.05га	16160 өрхөд 768.48га	16.7%


2.	Булган	13252	3933.78га	127 өрхөд 63.5га	1.6%
3.	Сэлэнгэ	21434	72072.38га	670 өрхөд 266.3 га	0.3%
4.	Дархан уул	14961	1962.95га	300 өрхөд 41.36га	2.1%

Энэхүү судалгааны дараагийн мэдээллүүдийг тус ТББ-аас явуулж буй судалгаатай харьцуулан судалж, дүгнэлт гаргах болно.

Газрын тухай болон МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг
сурталчлах, хэрэгжилтийг мэдээлэх талаар

Хуулийг сурталчилж ойлгуулах, хуулийн хэрэгжилт, газар олголтын мэдээ, мэдээлэл, төр засгаас авч явуулж буй арга хэмжээ, нийгмийн янз бүрийн давхаргын үзэл бодол, газрын албаны мэргэжилтнүүдийн тайлбар, ярилцлага, асуулт хариулт зэргийг өдөр тутмын болон шар сонинууд өргөнөөр нийтэлж, радио телевиз олон түмэнд мэдээллийг түгээж байна..

Хэвлэлд гарсан мэдээллүүдийг ангилж үзэхэд Үнэн сонинд 32, Өдрийн сонинд 27, Өнөөдөр 24, Улаанбаатарын мэдээ 2, Монголын мэдээ 27, Ардын эрх 5, Засгийн газрын мэдээ 4, Зууны мэдээ 8, Улаанбаатар таймс 7, Залуучуудын үнэн 1, Аугаа үндэстэн 1, Хөдөлмөр 2, Монгол таймс 1, Үг 1, бүгд 142 мэдээлэл гарсан байна.



Үнэн сонинд гарсан мэдээлэл 22.5%, Өдрийн сонины мэдээлэл 19.0%, Монголын мэдээ сонинах 19.0%, Өнөөдөр сонинах 16.9% -ийг тус тус эзэлж байгаа нь эдгээр сонинууд газар өмчлөлийн асуудалд нилээд анхаарч байгаа нь харагдаж байна.

Судалгааны явцад эдгээр хэвлэлүүдэд Газар өмчлөлийн талаархи мэдээ, мэдээлэл 23, Газрын албаны мэргэжилтнүүдийн албан ёсны тайлбар 26, Улс төрийн зүтгэлтнүүдийн явуулсан илгээлт, хэлсэн үг 6, газар өмчлөл ба цөлжилтийн талаар асуудал дэвшүүлсэн өгүүлэл 2, УИХ-ын гишүүдийн санал бодол 15, жирийн иргэдийн санал бодол 19, газар олголтын талаархи зөрчил баримт 5, сэтгүүлчийн санал бодол 12, судалгаа, санал асуулгын дүн 3, эрдэмтэн судлаачдын үзэл бодол 17, УИХ-ын хуралдаан 1, үндэсний зөвлөлийн хуралдаан 3, байнгын хорооны хуралдаан 2, сөрөг намын үзэл бодол 2, иргэдээс авсан асуулт, хариулт 4, газар өмчлөлийн талаар гарсан гадаадын туршлага 5, гадаад орноос МУ-д сууж буй элчин сайдын санал бодол 2, МҮЭ-ийн холбооны үзэл бодол 2, ГШХТ хөдөлгөөний санал бодол 3, УИХ-ын хуралдаан 1 дугаарт тус тус нийтлэгдсэн байна.

Эндээс харахад мэдээ, мэдээлэл 14.7%, газрын албаны мэргэжилтнүүдийн тайлбар мэдээлэл 16.6%, иргэдийн санал бодол 12.2%, эрдэмтэн судлаачдын үзэл бодол 10.9%, сэтгүүлчдийн санал бодол 7.7%, УИХ-ын гишүүдийн үзэл бодол 9.6%-ийг эзэлж байгаа нь газрын мэргэжилтнүүдийн зүгээс өгч буй мэдээлэл нилээд давамгайлж, иргэд, УИХ-ын гишүүд, эрдэмтэн судлаачид газар өмчлөлд их ач холбогдол өгч анхаарч байгаагийн илрэл бөгөөд харин төр, засгийн зүгээс мэдээлэл өгөх, ялангуяа хэвлэлийн мэдээ, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

“Үнэн” сонин 2002 оны 8-р сараас эхлэн УИХ-ын 2002 оны хаврын чуулганаар хэлэлцэж баталсан зарим хууль, УИХ-ын бусад шийдвэрийн талаар товчлон гол агуулгыг тайлбарлаж өгөхийг хүссэн уншигчдын хүсэлтээр “Хуулийн тайлбар” булан нээж Газрын тухай хуулийн гол тайлбаруудыг цувралаар нийтэлж гаргасан байна.

2.4. Газрын статистик мэдээнд дүн шинжилгээ хийх


Зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшин тогтох буй сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төр, засгаас улс орны оршин тогтохын үндэс, үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл, хүн ардын амьжиргааны гол эх үүсвэр, үл хөдлөх хөрөнгийн сонгодог хэлбэр болсон газрын харилцааг боловсронгуй болгоход чиглэгдсэн эрх зүйн орчинг бий болгож түүнийг хууль зүйн хүрээнд хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байна. Энэхүү бодлого, түүнийг хэрэгжүүлэх дэс дараатай арга хэмжээг газрын шинэтгэл хэмээн нэрлэж байгаа билээ.

Газрын шинэтгэлийн гол зорилго нь эрх зүйн хувьд баталгаатай, эдийн засгийн хувьд үр ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй, нийгмийн хувьд эрх тэгш байх үндсэн зарчимд тулгуурласан, үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн байх ёстой бөгөөд Монгол улсын иргэд газрыг өмчлөх, баталгаатай эзэмших эрхийг зах зээлийн нийгмийн шаардлагад нийцүүлэн буй болгоход оршино.

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 156.4 сая га бөгөөд үүний 73.9% буюу 115.6 сая/га нь ХАА-н газар, 0.28% буюу 432.9 мян/га нь хот, тосгон, бусад суурины газар, 0.23% буюу 353.0 мян/га нь зам, шугам сүлжээний газар, 9.38% буюу 14.6 сая/га нь ойн сан бүхий газар, 0.6% буюу 943.4 мян/га нь усны сан бүхий газар, 15.6% нь буюу 24.4 сая/га нь улсын тусгай хэрэгцээний газар байна.

Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын эзлэх хувь

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Нийт газар өмчлөгч ирээдийн тоо	Өмчлөлд буйг газрын нийт хэмжээ /га/	Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүй өмчилсөн	Гэр бүлийн хэрэгцээнд үнээр нь худалдаж авсан	Аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдаж авсан	Аж ахуйн зориулалт аардууллага худалдаагаар худалдаж авсан	Газар тариалан гийн зориулалт таардавуу эрхээр худалдаж авсан	Газар тариалангийн зориулалтаар худалдаагаар худалдаж авсан	Хөдлөх хөрөнгийн татвар ногдуулалт санчлэгчтэй тэрэлтүүд хөдлөх хөрөнгийн татварын орлогын хамгаалалтадаас



				иргэдийн тоо	газрын хэмжээ /га/			иргэдийн тоо	газрын хэмжээ /га/			иргэдийн тоо	газрын хэмжээ /га/			иргэдийн тоо	газрын хэмжээ /га/	
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	
1	Архангай	313	64.52	282	52.5 2			31	12									
2	Баян-Өлгий	49	5.94	49	5.94													
3	Баянхонгор	710	99.75	710	99.7 5													
4	Булган	127	63.5	127	63.5											22 .57 .8		
5	Говь-Алтай	17	1.58	17	1.58													
6	Говьсүмбэр	20	1.7	20	1.7													
7	Дархан-Уул	300	41.36	300	41.3 6													
8	Дорноговь	227	37.082	227	37.0 82													
9	Дорнод	94	11.1	94	11.1													
10	Дундговь	182	19.9	182	19.9													
11	Завхан	42	14.7	42	14.7													
12	Орхон	514	50.7	514	50.7													
13	Өвөрхангай	110	5.64	110	5.64													
14	Өмнөговь	490	42.47	490	42.4 7													
15	Сүхбаатар	179	21.37	179	21.3 7											92 .17 .5		
16	Сэлэнгэ	670	266.3	670	266. 3													
17	Төв	780	240.8	780	240. 8													
18	Увс	37	6.26	37	6.26											48 00 00		
19	Ховд	70	6.25	70	6.25													
20	Хөвсгөл	355	66.6	355	66.6													
21	Хэнтий	424	102.96	423	97.9 6					1	5							
22	Нийслэл	16169	769.14	16160	768. 48	9	0.66											
	ДҮН	21879	1939.6 22	21838	192 1.96 2	9	0.66	31	12	1	5	0	0	0	0	49 14 75	0	

/2003 оны жилийн эцсийн тайлангаас авлаа/

2.5. Төслийн үйл ажиллагааны талаархи сурталчилгаа.

Хэвлэлийн бага хурал

Төслийн үйл ажиллагааны талаар хэвлэлийн хүрээлэнд бага хурал зохион байгуулав. Хуралд Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, зөвлөх Н.Дорждарь нар урилгаар оролцож, Газрын шинэлгэлийн мониторингийн талаар хэрэгжүүлж буй төсөл нь олон түмэнд бодит мэдээллийг хүргэх зорилготойг тайлбарлаж, төслийн удирдагч доктор, профессор Г.Пүрэвцэрэн: МУ-д анх удаа ийм том төсөл хэрэгжиж байна, төслийн хүрээнд судалгааг байгаль нийгмийн талаас бүс нутагт явуулж, өөрсдийн судалгааны үндсэн дээр дүгнэлт гаргана гээд төслийн хүрээнд хийж буй ажлын талаар TV-9 телевиз болон сэтгүүлчдийн асуултад тодорхой хариултуудыг өглөө. Хуралд Монголын радиогийн “Хурд” агентлаг болон Монголын мэдээ, Хөх толбо, Olloo online сэтгүүл, Үнэн, Дэм, Өдрийн сонины сэтгүүлч сурвалжлагчид оролцлоо.

Радио нэвтрүүлэг

Монголын радиогийн “Шинэ-Эрин” радиостанцын “Газар тэнгэр” нэвтрүүлгээр төслийн үйл ажиллагааг сурталчлах цуврал нэвтрүүлгийг явуулах гэрээ байгуулж, эхний нэвтрүүлгийг 7 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулаад байна.

Мөн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Цагааннуур сум, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт хийсэн санал асуулгын дүнг Соросян сангийн вэб сайтад оруулахаар бэлэн болгоод байна.

“Хөгжил орон нутгаас эхэлнэ” сэтгүүлд “Газрын шинэлгэлд мониторинг хийх” төслийн хүрээнд хийж буй ажлын талаар ярилцлага өгсөн. Уг сэтгүүл нь 21 аймгийн 300 гаруй суманд тараагдах юм.

2.6. Шүүхийн байгууллагад газрын талаар гарсан өргөдөл, гомдлын судалгаа /Баянгол дүүрэг/

Баянгол дүүргийн шүүхийн байгууллагад газартай холбогдон ирсэн өргөдөл, гомдлыг судлан анализ хийж байна./Судалгаа дуусаагүй байгаа болно/

2.7. Цагдаагийн байгууллагад гарсан өргөдөл, гомдлын судалгаа /Баянгол дүүрэг/

Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэст газрын талаар гарсан өргөдөл, гомдлыг судлан үзэхэд 2000 оноос хойш газрын талаар өргөдөл, гомдол бараг ирээгүй, харин саяхан 2004 оны 7 сарын сүүлчээр газар эзэмшихтэй холбогдсон нэг өргөдөл ирсэн байна. Иргэд газартай холбогдсон өргөдөл, гомдлоо Иргэний хуулийн дагуу шууд шүүхэд өгдөг юм байна.

2.8. Улсын хэмжээний хууль, тогтоомжийн зөрчилд үнэлгээ хийх

Улсын хэмжээнд газартай холбогдсон хууль, тогтоомжийн зөрчил, түүнийг арилгах талаар болон хэрхэн шийдвэрлэж байгаа талаар судалгаа хийж байна.

Энэхүү судалгааны үр дүнд газартай холбогдсон зөрчил хэнээс, юунаас болж гарч байгаа талаар мэдээлэл авч түүнд үнэлгээ хийх зорилготой юм.

Байгаль 21 ТББ

2004.7.26.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

Дугуй ширээний ярилцлагын протокол

Улаанбаатар хот.

2004.5.13.

“Байгаль 21” ТББ-аас ННФ-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн хүрээнд зохион байгуулсан дугуй ширээний ярилцлага “Sky” зоогийн газарт 2004 оны 5 сарын 13-ны өдрийн 9.30 цагт эхлэв.

Ярилцлагад: МУИС-ийн багш, доктор, профессор Г.Пүрэвцэрэн, Геоэкологийн хүрээлэнгээс н. Аваадорж, н.Баасандорж, ХАА-н хүрээлэнгийн бэлчээр тэжээлийн секторын эрхлэгч доктор н.Цэрэндаш, Өмнөговь аймгийн газрын албаны дарга П.Золжаргал, Сүхбаатар аймгийн газрын албаны дарга Г.Гомбосүрэн, Дорнод аймгийн газрын даамал н.Лхүндэв, Сэлэнгэ аймгийн газрын мэргэжилтэн н.Батдэлгэр, Төв аймгийн газрын албанаас М.Хүрэлбаатар, Багануур дүүргийн газрын албаны дарга н.Бүжинлхам, Ховд аймгийн газрын албанаас Ч.Баатаржав, Нийслэлийн газрын албаны В.Пүрэвсүрэн, Р.Төрбат, н.Уранбайгаль, Баянгол дүүргийн газрын албаны Х.Пүрэвсүрэн, Эко-Ази ДС-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон эрх зүй, экологийн ангийн оюутнууд оролцлоо.

Ярилцах асуудлууд:

- 1.”Газрын шинэтгэлийн мониторинг” төслийн талаар танилцуулах
- 2.Төслийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнийг сонгох
- 3.Төслийн хүрээнд хийх ажлын удирдамж, төлөвлөгөө, хуваарь гаргах
- 4.Газар өмчлөлийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл солилцох
- 5.Чөлөөт ярилцлага

Ярилцлагыг “Байгаль21” ТББ-ийн тэргүүн Ж.Осоржамаа нээж үг хэлэв.

Энэхүү төслийг 2004 оны 4 сараас эхлэн нэг жилийн хугацаатай хэрэгжүүлэх юм.

“Газрын шинэ тгэлийн мониторинг” төсөл нь Газрын шинэ тгэлийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомжуудыг төв, орон нутагт хэрэгжүүлэхэд гарч буй эрсдлүүд түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавруудыг судлах, хуулийн хэрэгжилтэд олон нийтийн оролцоо, хяналтын механизмыг сайжруулах, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг ил тод, шударга, тэгш явагдаж байгаа болон иргэдэд газартай холбогдсон мэдээлэл хир нээлттэй байгааг судлах, хуулийн хэрэгжилтийг сонгосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд судалж дүгнэлт, зөвлөмжийг гаргах, хууль тогтоомжуудын хэрэгжилтэнд ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Төслийн хүрээнд суурин болон хээрийн судалгаа явуулж, Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын статистик мэдээллийг боловсруулж, дүгнэлт гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа газрын талаархи төрөл бүрийн мэдээллийг цуглуулан мэдээллийн дэд сан байгуулж, тэдгээрт дүгнэлт хийх, сонгосон нэгжид газрын мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулж, шүүх, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагуудад газрын талаар гарсан зөрчил, өргөдлийг хэрхэн шийдвэрлэж буйг судлах, санал асуулга явуулан мэдээлэл цуглуулж судлах, ТББ-аас хийж буй ажлын талаар хэвлэлийн бага хурал, семинар зохион байгуулж, судалгааны үр дүн болон шийдвэрлэх шаардлагатай асуудлыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд сурталчлах ажлуудыг зохион байгуулна гэж ярилаа.

Дараа нь төслийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнийг танилцуулав.
Үүнд:

1. Төслийн удирдагчаар МУИС-ийн багш, доктор, профессор Г.Пүрэвцэрэн
2. Төслийн хэвлэл мэдээллийн экспертээр доктор Д.Энэбиш
3. Төслийн хотын газар зохион байгуулалтын экспертээр Ц.Бадам
4. Төслийн бэлчээрийн экспертээр Ж.Даваабаатар
5. Төслийн ТХГНутгийн экспертээр Ч.Дашчирэв
6. Төслийн ашигт малтмалын экспертээр Ж.Осоржамаа
7. Төслийн ажилтан Б.Алтанцэцэг
8. Төслийн туслах ажилтан М.Уран-өлзий
9. Эко-Ази ДС-ийн оюутан Ц.Мөнхбат
10. Эко-Ази ДС-ийн оюутан Ж.Урансайхан
11. Эко-Ази ДС-ийн оюутан Г.Дэлгэрмаа

Төслийн удирдамж, төлөвлөгөөний талаар төслийн удирдагч Г.Пүрэвцэрэн ярихдаа: Энэхүү төсөл нь манай улсад анх удаа хийгдэж буйгаараа онцлог юм.

Уг төслийн хүрээнд батлагдан гарсан “Газрын тухай” хууль болон “Муны иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн хэрэгжилтэнд ард иргэд, төрийн бус байгууллагаас тавих хяналтын механизмыг бий болгох, байгаль нийгмийн талаас нийслэл, аймгийн төв, сум, дүүрэг зэрэг бус нутгийг сонгон авч ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд санал асуулгаар судалгаа явуулах, малчид тариаланчдын санал хүсэлтийг авч судлах, шүүх болон цагдаагийн байгууллагаас ард иргэдийн гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаад дүн шинжилгээ хийж, төслийн хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэн өөрсдийн дүгнэлтийг гаргаж, түүнийгээ хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж сурталчлах, гарсан санал хүсэлтийн дагуу шийдвэрлэвэл зохих асуудлуудыг дээд шатны албан тушаалтан болон эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, төслийн ажлын үр дүнгээр зөвлөмж гаргах зэрэг ажлуудыг гүйцэтгэх юм.

Төслийг 2004 оны 4 сараас эхлэн жилийн хугацаанд үйл ажиллагааны 4 үе шаттайгаар төлөвлөгөө, график гарган хэрэгжүүлж, үе шат бүрээр хийсэн ажлын тайланг бичиж, явц, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж ажиллахаар ярьж тохиролцов.

Төслийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө, 4 үе шатанд хэрэгжүүлэх ажлын график, хуваарь гаргах, бусад ажлын талаар төслийн экспертууд болон ажилтан нарт тодорхой үүрэг даалгавруудыг өглөө.

Төслийн удирдамжийн дагуу сонгосон засаг захиргааны нэгжүүдэд экспертууд болон төслийн ажилтнууд, мөн Эко-Ази ДС-ийн мэргэжлийн ангийн оюутнуудыг төлөвлөгөө, хуваарийн дагуу ажиллуулахаар тогтоо.

Дараан нь газрын шинэ тгэлийн мониторинг төслийг хэрхэн хэрэгжүүлэх талаар солилцож, асуулт хариулт явагдлаа.

БГД-ийн газрын албаны Х.Пүрэвсүрэн: Төслийн хүрээнд дүүргүүдэд ямар зарчмаар судалгаа явуулах вэ?

Ж.Осоржамаа: Дүүргүүдэд судалгаа хийхдээ гол нь газрын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн ил тод, нээлттэй байдал ямар байгаа, хуулийн хэрэгжилтэнд олон нийтийн оролцоо, хяналт тавих боломж хир байгаа, газар олголтын явцын талаар, газар өмчлөх ажлын явцад гарч буй зөрчил маргааны талаар иргэдийн санал хүсэлт ямар байгааг судлах болно.

Нийслэлийн газрын алба н.Уранбайгаль: Газар өмчлөлийн явцад иргэдийн эрх зөрчигдөх байдал их ажиглагдаж байна. Энэ талаар ямар зарчим баримталж судалгаа хийх вэ?

Ж.Осоржамаа: Төслийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гарсан санал гомдлыг тухайн орон нутгийн шүүх, цагдаагийн байгууллага болон газрын албад, шийдэх эрх мэдэл бүхий төрийн байгууллага, түшмэдийн зүгээс хэрхэн шийдвэрлэж байгаа болон хүний эрхийг хангахад хир зэрэг анхаарч байгаа талаар зохих байгууллагуудтай хамтран судалгаа хийж үр дүнг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж сурталчлах юм.

13.00 цагаас өдрийн зоог

14.20 цагаас дугуй ширээний ярилцлага үргэлжлэв.

Доктор н.Аваадорж: Өнөө үед байгалийг хамгаалахаасаа илүү ашиглах асуудал яригдах боллоо. Миний бодлоор төрийн бодлого ч бай, ТББ-ийн үйл ажиллагаа ч бай байгаль хамгаалах асуудлыг тэргүүн ээлжинд анхаарч дараа нь ашиглалтын асуудлыг зохицуулж, хамгаалах ашиглах ажлыг уялдаатай иж бүрэн төлөвлөмөөр санагдах юм. Төслийн судалгаанд байгаль хамгаалах талаар ямар зарчим баримтлан хэрэгжүүлэх гэж байгаа талаар сонсмоор байна.

Г.Пүрэвцэрэн: Ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас авах санал асуулга, ярилцлагадаа газар өмчлөлийн үйл явц нь эдийн засаг-нийгэм-байгаль орчны хоорондын уялдаа холбоонд хэрхэн нийцэж байгаа талаар тодорхой асуултуудыг тусгаж, түүний дагуу санал бодол, мэдээллийг авч газар дээр нь явж судалж, анализ хийсний эцэст дүгнэлт гаргах болно.

Эко-Ази ДС-ийн оюутан Ц.Мөнхбат: Энэ төслийн судалгаанд нутаг дэвсгэрийн ямар нэгж, газар ашиглалтын ямар хэлбэр хамрагдаж байгаа бол?

Г.Пүрэвцэрэн: Судалгааг манай оронд байгаа газар ашиглалтын бүх хэлбэрүүдийг хамруулан явуулж, дүгнэлт гаргах зорилт тавьж байгаа бөгөөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрийн төлөөллийг хамруулан хийх юм.

Ж.Осоржамаа: Бид судалгаандаа хотын газар ашиглалт, дуудлага худалдаа, иргэдийн хашаа байшингийн газар олголт, улсын тусгай хамгаалалттай газар,.govийн бүсийн билчээрийн газар ашиглалт, аймаг дундын отрын нутгийн газар ашиглалт, ашигт малтмал ашиглалт, ашигт малтмал-МАА хоорондын зөрчил, Эдийн засгийн чөлөөт бүсийн газар ашиглалт, хилийн зурvas болон бүс нутгийн газар ашиглалт, Газар тариалангийн гол бүс нутаг, газар тариалан-МАА-н хоорондын харилцааг судлахаар тодорхой нэгжүүдийг сонгож аваад байна.

Эко-Ази ДС-ийн оюутан Ж.Урансайхан : Газар өмчлөлийн хуулийн талаар мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байх юм. Энэ талаар төсөл хэрэгжүүлэх явцад ард иргэдэд мэдээллийг яаж хүргээ гэж бодож байна вэ?

Ж.Осоржамаа: Судалгааны ажлын үе шатуудад хэвлэлийн бага хурал, ярилцлага семинар, онол практикийн бага хурлыг төрийн болон төв орон нутгийн байгууллагуудын төлөөлөл, олон нийт, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор 3-4 удаа зохион байгуулна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, судалгааны ажлын явц, үр дүнгийн талаар олон нийтэд байнга мэдээлж ажиллах болно.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ч.Дашчирэв: 1999 онд Горхи, Тэрэлжийн БЦГ болон Богдхан уулын ДЦГ-ын газар ашиглалтын байдлыг судлан үзэж даацад нь тохируулан тодорхой чиглэлийг гаргаж байгаль орчны сайдын тушаалаар батлан мөрдүүлсэн юм. Сураг сонсвол тэр тушаалыг хүчингүй болгож газар нэмж олгож байгаа сургтай. Тэр үед л газрын даац хэтэрсэн байсан. Одоо ч бүр замбараагаа алдсан байх. Энэ талаар та бүхний судалгааны программд тусгагдсан болов уу?

Ж.Осоржамаа: ТХГН-ийн тухайд Горхи, Тэрэлжийг сонгосон. Тэнд ТХГН-ийн газар ашиглалт ямар байгааг мэргэжлийн хүмүүсийн хамт газар дээр нь очиж судлах зорилготой байгаа бөгөөд хууль, тогтоомжийн ямар заалт

зөрчигдөж байна, мөн ТХГН-ийг зориулалтаар нь ашиглаж буй эсэх, газар олголт хир зөв зүйтэй явагдаж байгаа талаар судалгаа хийж, хяналт тавьж ажиллах юм.

Доктор н.Цэрэндаш: Сүүлийн үеийн судалгаагаар манай орны нийт бэлчээрийн 70% нь талхлагдсан гэсэн мэдээ байгаа. Энэ нь голдуу төвлөрсөн хот, суурины ойролцоо газрыг хамарч байгаа юм. Газрын хуулинд хот, суурин газрын ойролцоо бэлчээрийн хуваарь, ашиглалтын талаар тодорхой тусгасан заалт ховорхон. Төслийн судалгаанд энэ чиглэлээр асуудал оруулж судалбал зүйтэй байх.

Ж.Осоржамаа: Энэ чиглэлээр судлахаар төлөвлөсөн байгаа. Тухайлбал: нийслэлийн дагуул Гацуурт, Багахангай, Багануур дүүрэгт хот орчмын бэлчээрийн ашиглалт, Өмнөговь аймгийн Сэврэй суманд говийн бүсийн билчээрийн ашиглалт, Төв аймгийн Заамар суманд бэлчээрийн газар ашиглалтын талаар судалгаа хийх юм.

Сэлэнгэ аймгийн газрын албаны мэргэжилтэн н.Батдэлгэр: Манай аймгийн хувьд тариалангийн талбайн эзэмшлийн асуудал ихээхэн анхаарал татаж байна. Улс төржих байдалд ч хүргэж байна. Энэ талаар гадаад онуудын туршлагыг судлан боломжтой хэлбэрүүдийг санал зөвлөмжиндөө оруулбал зүгээр байна.

Өмнөговь аймгийн газрын албаны дарга П.Золжаргал: Говь гурван сайхны БЦГ-ын орчны бүсэд хамрагдаж байгаа сумдын бэлчээрийн асуудал нилээд хүндрэлтэй байдаг. Энэ бүсэд Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Байгаль хамгаалал ба орчны нутгийн хөгжил” төсөл амжилттай хэрэгжсэн. Одоо Шинэ Зеландын “Хүн төвтэй байгаль хамгаалал” төсөл хэрэгжиж тодорхой ажлуудыг зохион байгуулж байна. Газар нутгийн ихэнх хувь нь ТХГН-т хамрагддаг Сэврэй сумд энэхүү төслийн судалгааны асуудал явагдах гэж байгаа нь туйлын ач холбогдолтой юм. Иймээс энд тохиолдож байгаа бэрхшээлийг даван туулах талаар тодорхой зөвлөмж гаргана гэдэгт итгэж байна. ТХГН-ийн тухай хуулийн БЦГ-ын хамгаалалтын дэглэмийн асуудалд ч эргэж хармаар зүйл бий санагддаг.

Доктор н.Баасандорж. Ашигт малтмол олборлосон газарт нөхөн сэргээлтийн ажлыг үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүд хийдэг өнөөгийн зохион байгуулалтаар энэ ажил үр дүнтэй явагдах боломжгүй нь нэгэнт тодорхой боллоо. Иймд нөхөн сэргээлтийн зардлыг тусгай дансанд төвлөрүүлж мэргэжлийн байгууллагуудаар хийлгэх шаардлагатай байна.

19.00 цаг хүртэл ярилцлага үргэлжилж, санал бодлоо солилцлоо.

19.00 цаг. Оройн зоог

Ярилцлагын тэмдэглэл хөтөлсөн ажлтан

Б.Алтанцэцэг

Хэвлэлийн бага хурлын хөтөлбөр /2004.7.7/
/ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй
“Газрын шинэлгэлд мониторинг хийх” төсөл/

1.Нээлт	Д.Энэбиш	12.30 цаг
2.Төслийн танилцуулга хийх	П.Эрдэнэжаргал Н.Дорждарь	12.35 цаг
3.Төслийн хүрээнд хийж буй ажлын талаар мэдээлэл хийж,дэлгэрэнгүй ярих	Г.Пүрэвцэрэн	12.40 цаг
4.Сэтгүүлчдийн асуулт, хариулт		12.45 цаг
5.Хаалт	Д.Энэбиш	13.00 цаг

Хөтөлбөр хийсэн

М.Золжаргал

Хэвлэлийн хүрээлэн

/2004.7.7/

Хэвлэлийн бага хурлын протокол

Байгаль 21 ТББ-аас зохион байгуулан ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэтгэлд мониторинг” төслийн үйл ажиллагааны талаар хэвлэлийн бага хурал хийлгэв.

Хурлыг “Байгаль 21” ТББ-ын хэвлэл мэдээллийн эксперт доктор Д.Энэбиш нээж, төслийн зорилгыг ярьж, хуралд оролцогсдыг танилцуулав

Хуралд ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал, менежер Н.Дорждарь нар урилгаар оролцов. Мөн Монголын радиогийн “Хурд” агентлаг болон Монголын мэдээ, Хөх толбо сонин, TV-9 телевиз, Olloo online сэтгүүл, Үнэн, Дэм, Өдрийн сонины сэтгүүлч сурвалжлагчид оролцлоо.

П.Эрдэнэжаргал: Газрын шинэтгэлийн мониторингийн талаар хэрэгжүүлж буй төсөл нь Газар өмчлөлийн хууль гарсантай холбогдуулан шинэтгэлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг харуулах, олон түмэнд бодит мэдээллийг хүргэх, газар өмчлөлийн эдийн засгийн үр ашиг, эрх зүйн хүрээний асуудлыг судалж бодлого боловсруулах, газар өмчлүүлэх хуулийн хэрэгжилтэнд хяналт тавихад иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, газар өмчлөлийн ажилд гарсан ололтыг нэгтгэн дүгнэж олон түмэнд хүргэх зорилготойг тайлбарлаж, төсөл хэрэгжсэнээр

а. Газар өмчлөлийн ажлын ололт амжилт болон эдийн засгийн эрх зөрчигдсөн баримт мэдээллийг цуглуулан судлах

б. Газар өмчлөлийн явцад гарч буй амжилт, алдааны олон түмэнд үзүүлж буй үр нөлөөний эрсдэлтэй тал, ач холбогдлыг судлах

в. Газар өмчлөлийн талаар төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх арга хэмжээг олон нийтэд хүргэх үр дүн гарах юм гэж ярилаа.

Төслийн удирдагч доктор, профессор Г.Пүрэвцэрэн: МУ-д Газрын шинэ тгэлийн талаар анх удаа ийм том төсөл хэрэгжиж байна. Төслийн хүрээнд Газар өмчлүүлэх хуулийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дараахи ажлуудыг хийж байна.

1. Газар өмчлөх, эзэмших ажлын явцыг нийслэл, аймгийн төв, сум, хөдөө орон нутагт ард иргэдээс санал асуулга авах замаар судалж байна.

2. Иргэдийн зүгээс газартай харьцсаны үр дүн ямар байна, газар өмчлөх, эзэмшихэд гарч байгаа гол саад бэрхшээл, маргаан зөрчлүүдийг судалж байна.

3. Судалгааг байгаль, нийгмийн талаас сонгон авсан аймаг, сум, дүүрэг зэрэг бус нутагт явуулж, өрх, иргэн, гэр бүлийн хүрээнд болон тариаланчид, малчдын санал бодлыг судалсаны үндсэн дээр ТББ-аас хийсэн судалгаандаа үндэслэн дүгнэлт гаргана.

4. Газар өмчлөлийн хууль гарахаас өмнө болон хууль гарснаас хойши хугацаанд олон нийтийн санал бодол ямар байгаа, газар өмчлөлийн талаархи маргаан, гомдол зэрэг мэдээллийг цуглуулан нэгтгэж мэдээллийн сан байгуулна.

5. Мөн шүүх, цагдаагийн байгууллагаас газар өмчлөлийн хуулийн хэрэгжилтэнд хэрхэн хандаж байгаа талаар судална.

6. “Байгаль 21” ТББ-аас газрын шинэ тгэлийн талаар хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга мэдээлнэ.

7. Газар өмчлөлийн хуулийн талаар болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гарсан санал хүсэлт, өөрсдийн хийсэн судалгаанд үндэслэн цаашид шийдэх шаардлагатай асуудлуудыг дээд шатны байгууллага, албан тушаалтанд тавина.

8. Газар өмчлөлийн ажил удаашралтай явагдаж байна. Бүртгэж, баталгаажуулсан нь бага байна. Ажилд дараахи дутагдлууд оршиж байна.

- Газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх ажил давхацсан байна.

- Ажлын явцад оролцдог байгууллага, албан тушаалтны ажлын уялдаа холбоо тааруу, хойрго байна.

- Газрын маргааны асуудлыг нийслэлийн газрын албаныхан шүүхээс өмнө авч шийдээд байна. Энэ нь зөв үү?

- Газрын талаар гарч байгаа маргаан 2 янз байна. Үүнд газар дээрхи эд хөрөнгийн маргааныг шүүхээр шийдэх хэрэгтэй. Харин газрын асуудлын хувьд

газар хувьчлалын албанаас гаргасан гомдлыг шүүхээр шийдвэрлэх нь зүйтэй гэж ярилаа.. .

Доктор, профессор Г.Пүрэвцэрэн төслийн хүрээнд хийж буй ажлын талаар TV-9 телевиз болон сэтгүүлчдийн асуултад тодорхой хариултуудыг өглөө.

“Байгаль 21” ТББ-ын танилцууга, төслийн танилцуулгыг сэтгүүлчдэд тараав.

Хурал 13.00 цагт завсарлав.

Протокол хөтөлсөн:

“Байгаль 21” ТББ-ын ажилтан Б.Алтанцэцэг

Хэвлэлийн бага хуралд оролцсон хэвлэл мэдээллийн жагсаалт

2004.7.7.

№	Байгууллагын нэр	Сэтгүүлчийн нэр	Утас
1.	Монголын радио “Хурд” агентлаг	Доржмаа	9981 5216
2.	Монголын мэдээ Сонин	Сосоржав	318720
3.	Хөх толбо Сонин	Ч.Бум	313405
4.	Olloo online сэтгүүл	Туул	9986 0407
5.	Үнэн сонин	Б.Чинбилэг	320482 323223 факс
6.	Дэм сонин	Л.Энхтүвшин	9114 6057
7.	Өдрийн сонин	Ч.Ану	9942 9337

**Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Алтанбулаг, Сүхбаатар
суманд судалгаа хийх удирдамж / 2004.7.8-11 /**

1.Зорилго:

Сэлэнгэ аймгийн эдгээр сумдаас эдийн засгийн чөлөөт бүсийн газар ашиглалт, хилийн зурvas болон бүс нутгийн газар ашиглалт, газар тараиалангийн гол бүс нутаг, хот суурингийн газар ашиглалт, газар тариалан болон мал аж ахуй хоорондын газрын харилцаа, ХАА-н барилга байгууламжийн газар ашиглалтыг судлах зорилгоор сум тус бүрийн иргэд, аж ахуйн нэгжээс санал асуулгын журмаар 100 саналыг авна.

2.Хугацаа: 2004.7.8-11.

3.Ажиллах чиглэл:

а.М.Золжаргал – /Алтанбулаг суманд /хилийн зурvas, эдийн засгийн чөлөөт бүсийн газар ашиглалтыг судлах /

б.Д.Энэбиш - /Газар тариалангийн гол бүс нутаг, хот суурин газрын газар ашиглалт, газар тариалан-МАА-н хоорондын газрын харилцааг судлах /

в. Батдэлгэр – Хот суурин газрын газар ашиглалт, ХАА-н барилга байгууламжийн газар ашиглалтыг судлах / Судалгааг авах оюутны баг 6 хүнийг хамт авч явах болно./

Удирдамж бичсэн

Д.Энэбиш

Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд судалгаа
явуулах ажлын хөтөлбөр /2004.7.8-11/

1. 7 сарын 8-нд:

Өглөө 4.00 цагт Улаанбаатар хотоос хөдөлнө.

8.30 цагт Сүхбаатар хотод очно.

9.00 цагт Сэлэнгэ аймгийн газрын албаны мэргэжилтэн Батдэлгэртэй уулзаж,
Цагааннуур сумын газар зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.

10.00 цагт Сэлэнгэ аймгийн төвөөс Цагааннуур сум руу хөдөлнө.

13.00 цагт Цагааннуур суманд очно.

13.00 цагт үдийн цай

14.00 цагт Цагааннуур сумын засаг даргатай уулзаж, төслийн талаар товч
танилцуулга хийнэ.

14.30 цагт Газар тариалан эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй танилцаж, хүмүүстэй
ярилцаж, судалгааны материал тарааж, санал асуулгын хуудас бөглүүлнэ.

15.00 цагт МАА эрхэлж байгаа бригадаар явж, иргэдтэй уулзаж ярилцана.

19.00 цагт Оройн хоол

2. 7 сарын 9-нд:

Өглөө 9.00 цагт Цагааннуур сумын иргэдтэй уулзаж ярилцахдаа судалгааны
материал тарааж, санал асуулгын хуудас бөглүүлнэ.

13.00 цагт үдийн хоол

14.00 Судалгаагаа үргэлжлүүлэн хийнэ.

19.00 Оройн хоол

3. 7 сарын 10-нд:

9.00 цагаас судалгааны ажлаа үргэлжлүүлнэ.

13.00 үдийн хоол

14.00 цагаас айл өрхөөр явж судалгаагаа хийнэ.

19.00 оройн хоол

4. 7 сарын 11-нд:

Өглөө 9.00 цагт Цагааннуур сумаас Сэлэнгэ аймгийн төв рүү хөдөлнө.

Хөтөлбөр хийсэн

Д.Энэбиш

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд судалгаа
явуулах ажлын хөтөлбөр /2004.7.8-11/

1. 7 сарын 8-нд:

Өглөө 4.00 цагт Улаанбаатар хотоос хөдөлнө.

8.30 цагт Сүхбаатар хотод очно.

9.00 цагт Сэлэнгэ аймгийн газрын албаны мэргэжилтэн Батдэлгэртэй уулзаж,
Алтанбулаг сумын газар зохион байгуулалтын талаар мэдээлэл авна.

10.00 цагт Сэлэнгэ аймгийн төвөөс Алтанбулаг сум руу хөдөлнө.

10.30 цагт Алтанбулаг суманд очно.

10.50 цагт Алтанбулаг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргатай уулзаж,
төслийн талаар төвч танилцуулга хийнэ.

11.30 Алтанбулаг суманд үйлдвэр, үйлчилгээ эрхэлж буй иргэдтэй уулзаж,
судалгааны материал тарааж, санал асуулгаар судалгаа явуулна.

13.00 цагт үдийн хоол

14.00 цагт санал асуулга авах ажлаа үргэлжлүүлнэ.

19.00 цагт оройн хоол

2. 7 сарын 9-нд:

9.00 цагт Алтанбулаг сумын иргэдтэй уулзаж, санал асуулгаа үргэлжлүүлэн
хийнэ.

13.00 цагт үдийн хоол

14.00 цагт Судалгааны ажлаа үргэлжлүүлнэ.

19.00 цагт оройн хоол

3. 7 сарын 10-нд

9.00 цагт Санал асуулга авах ажлаа үргэлжлүүлнэ.

13.00 цагт үдийн хоол

14.00 цагаас судалгааны ажил явуулна.

19.00 оройн хоол

4.7 сарын 11-нд:

9.00 цагт Алтанбулаг сумаас Сэлэнгэ аймгийн төв рүү хөдөлнө.

Хөтөлбөр хийсэн

М.Золжаргал

**Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд хийсэн
судалгааны ажлын тэмдэглэл**

2004.7.8-11-д Алтанбулаг суманд Газар өмчлөлийн хуулийн хэрэгжилт, газар олголтын талаар судалгаа хийлээ. Үүнд:

Уб хотоос Сэлэнгэ аймгийн төвд 2004.7.8-ны өглөөний 9.00 цагт ирэв.

9.30 цагаас Сэлэнгэ аймгийн засаг дарга н.Нямсүрэнтэй уулзаж “Байгаль 21” ТББ-аас ННФ-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэ тгэлийн мониторинг” төслийн талаар товч танилцуулга хийв.

Мөн аймгийн Байгаль хамгаалах албаны дарга н.Цэнгэлзаяатай уулзаж төслийн талаар товч танилцууллаа.

Сэлэнгэ аймгийн Газрын албаны мэргэжилтэн н.Батдэлгэртэй уулзаж, ТББ-аас хэрэгжүүлж буй төслийн талаар мэдээлэл хийж, Алтанбулаг сумын газар өмчлөлийн ажлын талаар мэдээлэл авч, Сэлэнгэ аймгийн Цагааннуур / газар тариалан /, Алтанбулаг / чөлөөт бүс / сумдуудаар явах, ярилцлага хийж санал солилцох, социологийн судалгаа явуулах ажлыг хамтран гүйцэтгэхээр ярьж тохиро.

Алтанбулаг сум нь чөлөөт бүсийн эдийн засгийн бүс нутаг юм. Нийт 210030 га нутаг дэвсгэртэй. ХАА-н эзэмшил газар 18.810.66 га, үүнээс билчээр 1.266 га, өвөлжөө хаваржааны газар 633 га, хадлан 9004 га, тариалангийн талбай 8429 габайгаагаас үр тариа тариалсан талбай 2823 га, төмс хүнсний ногоо тариалсан 117 га, уриншилсан талбай 2832 га байна.

Мөн ХАА-н барилга байгууламжийн газар 79,053 га, МАА-н үйлдвэрлэлийн талбай 71.5 га байна. Хот, суурингийн газар 1488 га, барилга байгууламжийн газар 25.99 га, амралт сувилалын газар 5.5 га, нийтийн эдэлбэрийн газар 1319 га, хог хаягдлын газар 10 га, үйлдвэрийн газар 15.32 га, гэр хороолол 126.09 га, эзэмшүүлэх болон ашиглалтад олгоогүй

сул газар 1280.74 га, зам, шугам сүлжээний газар 766 га, чөлөөт бус 500га газрыг эзэлж байна.

11.30 цагт Алтанбулаг суманд ирэв.

Сумын захиргаан дээр очиход ажилтнуудын олонхи нь амарсан байв.

Алтанбулагийн төв дээр ард иргэдийн дунд санал асуулгын хуудсаа тарааж бөглүүлэв.

Мөн энэ явцад хүмүүстэй уулзаж ярилцан, тэдний санал гомдлыг сонсож тэмдэглэн авлаа.

- Иргэн О – Энэ суманд ирээд нэг жил гаруй болж байна. 2003.6 сард газар тариалангийн зориулалтаар газар өмчлөх өргөдлөө гаргаж газрын даамалд өгсөн боловч өдий хүртэл шийдэгдээгүй байна. Учрыг лавлахад иргэдийн нийтийн хурал хуралдахгүй байна гэсэн хариулт өгдөг. Мөн сумын төвд 0.0.7 га газар өмчлөх хүсэлтээ тавьж газраа сонгон үзүүлэхэд тэр газрыг чинь өөр хүн авчихсан байна гэдэг. Гэвч тэр газарт одоо болтол нэг чайл буугаагүй, хашаа бариагүй байгаа. Иймд би гомдолтой байна гэлээ.

- Иргэн Б – Манай нутагт чөлөөт бус гэж яриад байгаа боловч юу ч хийхгүй байна. Сая 2 дахь удаагаа шав тавилаа. Энд ямар ч үйлдвэр байхгүй, нутгийн иргэд наймаа хийдэг, гэтэл оросын тал хятад барааг оруулахаа болиод удаж байна, бид бараагаа орос руу гаргах гэж маш их татварын дарамтанд орж байна. Эдийг засгийн чөлөөт бус болж татварын татварын хэмжээг бууруулахыг хүлээсээр өдий хүрлээ. Одоо үнэхээр итгэл алдарч байна.

Алтанбулаг сумын газрын албаны мэргэжилтэн Отгонцогттой уулзах гэсэн боловч амралттай байлаа.

Тус сумын захиргааны мэдээллийн самбарт Засаг даргын 6 сард гарсан захирамжаар нийт 55 өрхөд гэр бүлийнх нь хэрэгцээнд зориулж газрыг өмчлүүлэхээр зарлал гаргасан байлаа. Уг захирамжид иргэдийн хашааны дундаж хэмжээ 2500м² гэж заасан байна.

Сумын ИТХ-ын 2003.12.25-ны өдрийн 49-р тогтоолыг үндэслэн Алтанбулаг сумын засаг дарга 2004.6.11-нд 52 тоот захирамж гаргаж нийт 55 өрхөд гэр бүлийн хэрэгцээнд нь зориулж газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлөх шийдвэр гаргасан байна. тариалангийн газар өмчлөх хүсэлтээ иргэн , харьяалах багийн засаг даргадаа зохих маягтын дагуу гаргах юм байна.

2004 онд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн 19 газруудын жагсаалт гаргасан байна.

Тухайлбал:

Хутаг-өндөр – талбайн дугаар 1/02, талбайн хэмжээ – 660га.46,47,49/02 - 16.24.116га

Давст - 41.42.43.45 – 537.101.292.118га.

Хяраан – 54-40га.

Мухар төхөм – 100.125.134.137 – 31.111.15.23 га.

Талын нуруу – 140/002 – 146 га. Нийт 2947 га.

Бидний олж мэдсэн албан бус мэдээгээр Алтанбулаг суманд 3600 иргэн амьдардаг. Сүүлийн жилүүдэд чөлөөт бус байгуулна гээд газар зохион байгуулалт тодорхойгүй, хүн амд өмчлөх газрыг хаана ямар бусийг хамруулан олгох нь тодорхойгүй байснаас бусад сумдыг бодвол газар өмчлөлийн ажил хоцронгуй явагдаж байгаа юм байна.

Алтанбулаг сумын газрын даамал н.Отгонцогтоос асуух асуудлуудыг Сэлэнгэ аймгийн газрын даамал н.Батдэлгэрт үлдээж хариу авахаар тохиролцов.

Бусад өдрүүдэд хөтөлбөрийн дагуу судалгааныхаа ажлыг явуулсан болно.
Санал асуулгын хуудас болон дүнг хавсаргав.

Тэмдэглэсэн:

М.Золжаргал

Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд явуулсан судалгааны ажлын тэмдэглэл

Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн явцад тохиолдож буй бэрхшээлийн талаар ард иргэдээс анкетийн судалгаа авах ажлыг 2004 оны 7 дугаар сарын 8-наас-11-нд Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд зохион байгуулав.

2004.07.08 Пүрэв гариг

Сэлэнгэ аймгийн засаг дарга н.Нямсүрэнтэй уулзаж “Байгаль 21” ТББ-аас “Нээлттэй нийгэм” форумын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Газрын шинэлгэлийн мониторинг” төслийн талаар товч танилцуулга хийв.

Сэлэнгэ аймгийн газрын албаны болон байгаль орчны алба, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтнуудтай уулзаж судалгаа хийх ажлын зорилго чиглэлээ танилцуулж газрын шинэлгэлийн чиглэлээр хийж байгаа ажилтай танилцав. Сүхбаатар хотод хийгдэх судалгааны ажлыг Батдэлгэр, Алтанбулаг сумаас авах судалгааны ажлыг М.Золжаргал, Цагааннуур сумаас авах судалгааны ажлыг Д.Энэбиш нар хариуцан зохион байгуулахаар ажил төрлөө хуваарилав. Энэ хугацаанд Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаатай танилцаж ТХГН-т газар ашиглах үйл ажиллагааг хэрхэн боловсронгуй болгох талаар ярилцав.

Улаанбаатар хотоос Сүхбаатар, Цагааннуурын чиглэлд УАЗ-469 маркийн машиныг зах зээлийн жишгээр үнэлэн авсан болно.

2004.07.09 Баасан гариг

Цагааннуур сумын засаг дарга, холбогдох ажилтнуудтай уулзаж судалгааны ажлын зорилго чиглэлийг танилцуулж газрын шинэлгэлийн ажил тус суманд хэрхэн явагдаж байгаатай танилцав.

Цагааннуур сум нь газар тариалангийн гол бүс нутаг бөгөөд энд газрын шинэ тгэлийн ажил өөрийн гэсэн өвөрмөц онцлогтойгоор хэрэгжиж байна. Томоохон аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн талбайг тэнд ажиллагсадад нь тодорхой хувиараар эзэмшүүлсэн байна. Ингэхдээ сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр гавъяа шагнал, ажилласан хугацаа зэргийг харгалзан эзэмшүүлэх газрын хэмжээг ялгавартайгаар тогтоожээ. Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулж буй талбайгаас тодорхой хувийг эзэмшсэн ажиллагсад талбайгаа аж ахуйн нэгждээ түрээслүүлэн өөрөө аж ахуйн нэгжид ажиллаж, ажлын хөлс болон талбайн түрээсийн хөлсөө аж ахуйн нэгжээс авдаг байна. Энэхүү зохион байгуулалтын талаар аж ахуйн нэгжийн захирал эзэд болон ажиллагсад шүүмжлэхгүй, харин ч ам сайтай байгаа нь энэ хэлбэр манай орны нөхцөлд боломжтой хувилбарын тоонд орж байгааг харуулж байна.

Сумын төвийн иргэд, төр захиргаа, олон нийтийн байгууллагуудын ажиллагсадтай уулзаж газрын шинэ тгэлийн ажлын талаархи мэдээлэлтэй танилцаж, сонирхсон асуултуудад хариулан харилцан ярилцаж анкетийн судалгааны асуултыг бөглүүлэв.

2004.07.10 Баасан гариг

